



АРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/39

Цэцэрлэг

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ТУХАЙ

Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, эмч мэргэжилтнийг мэргэжлийн алдаа эрсдэлээс сэргийлэх, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлагыг сайжруулах ЭМС-ын 2012 оны 375 тоот тушаал, 2013 оны 01сарын 04-ны өдрийн 1а/36 тоот албан даалгаврыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор **ТУШААХ** нь :

1.Эрүүл мэндийн байгууллагуудын дарга эрхлэгч нарыг Чанарын картаар үнэлэх журмыг нэгдүгээр, чанарын картын загварыг хоёрдугаар, чанарын карт хэрэглэсэн тайлан гаргах загвар хүснэгтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Байгууллагын түвшинд “Чанарын картаар эмч мэргэжилтнүүд, ажилчдын ажлыг үнэлэн ажиллах журам”-ыг боловсруулан, үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллаж, тайланг хагас, бүтэн жилээр ЭМГ-т ирүүлж байхыг Эрүүл мэндийн байгууллагуудын дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Эрүүл мэндийн байгууллагуудын дарга эрхлэгч нарын ажлыг журмын дагуу Чанарын картаар үнэлэн урамшуулал, хариуцлага тооцох санал боловсруулан албан бичгээр хагас, бүтэн жилээр орон нутгийн Засаг даргын тамгын газарт болон ЭМБ-уудад хүргүүлэн, хяналт тавьж ажиллахыг ЭМГ-ын орлогч дарга /Г.Мандах/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Р.ГАНДИЙМАА

ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГООР ЧАНАРЫН КАРТ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Зорилго : Эмнэлгийн тусламж ялангуяа эх хүүхэд яаралтай тусламжийн чанарыг сайжруулах , мэргэжлийн алдаа эрсдэлээс сэргийлэх, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлагыг сайжруулах ЭМСайдын тушаал, албан даалгавруудыг хэрэгжүүлэхэд оршино.

Зорилт :

1. Тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах
2. Мэргэжлийн алдаа эрсдэлээс сэргийлэх
3. Хариуцлага сахилгыг сайжруулах
4. Ажлын бүтээмж, санаачлагыг өрнүүлэх

Чанарын картны хэлбэр:

1. Ногоон –урамшууллын карт
2. Шар –анхааруулгын карт
3. Улаан – хариуцлагын карт

Чанарын карт ашиглах заалт:

Ногоон карт олгох заалт:

Эрүүл мэндийн бүх шатлалын байгууллагат хамааралтай заалт:

1. Жирэмсний эрт хяналтыг 95%-д хүргэсэн байх(бодитоор)
2. Жирэмсэн эхийг үзлэг шинжилгээнд 100% хамруулсан байх
3. Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд байгууллагын түвшинд чанарын өдөрлөг, болзолт уралдаан, нээлттэй хаалганы өдрийг улирал бүр зохион байгуулж үр дүнг тайлагнасан байх
4. Дутуу нярайн амьдрах хувийг нэмэгдүүлсэн байх төрөх үеийн хүндрэлийг бууруулсан байх
5. Төрөх өрөө, хагалгааны өрөө, нярайн өрөөний хэмийг 25-28 градусд тогтмол барьж хэвшсэн байх
6. Сэхээн, эрчимт эмчилгээний өрөөг стандартын түвшинд багаж хэрэгсэлээр хангасан, үйл ажиллагаа жигдэрсэн байх
7. Хяналтын болон төрөлтийн явцад ураг амьгүй болох тохиолдол гаргаагүй байх
8. Хүүхдийн эндэгдэлгүй ажилласан байх
9. Хүүхдийн тусламжаар ХӨЦМ болон хүүхдийн зонхилон тохиолдох өвчний удирдамжийг хэрэгжүүлж хэвшсэн байх (Нярай болон хүнд хүүхэд тээвэрлэх заалтуудыг хэрэгжүүлэн ажилласан байх)
10. Яаралтай дуудлагаар үйлчлэх журмыг мөрдөн жагсаалтад орсон өвчний назологоор тусламж үйлчилгээг үзүүлэн дуудлагын гүйцэтгэлийн хугацаа,

хүртээмж, мэргэжлийн чадвараар гомдол гараагүй, иргэд болон хөндлөнгийн хяналтын үнэлгээгээр сайн үнэлэгдсэн байх

Нэгдсэн эмнэлэгт хамааралтай заалт

1. Кесеревохагалгааны хувийн 23-аас доош бууруулсан байх (өмнөх оноос бууруулсан байх)
2. ЖЗӨК-д оношилгооны өрөө гарган ЭХО, ургийн монитор бусад хэрэгслээр ханган үйл ажиллагаа жигдэрсэн байх
3. 2дахь шатлалд ирж буй эхчүүдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд бүрэн хамруулсан байх
4. Онцгой тохиолдолд мэргэжлийн ур чадвар гарган эхийн амь насыг аварсан бол
5. Хоног болоогүй нас баралтыг өмнөх оны мөн үеэс 50-с доош хувиар бууруулсан байх

СДЭ.СӨЭМТөвтэй хамааралтай заалт

1. Сум хариуцсан эх барихын эмчтэйгээ хамтран ажиллаж сумандаа 2-с дээш удаа урьж сургалт, үзлэг зөвлөлгөө авч ажиллан үр дүн гаргасан байх
2. Хоног болоогүй нас баралт гаргаагүй байх
3. Ховор хүнд тохиолдлуудад анхдагч сэхээн амьдруулалтыг цаг алдалгүй шуурхай хийж өвчтөний амь насыг аварсан.

Шар карт олгох заалт:

Эрүүл мэндийн бүх шатлалын байгууллагад хамааралтай заалт:

1. Төрсөний дараа 42 хоногт эргэн хэвтсэн тохиолдол
2. Гэрийн төрөлт гаргасан тохиолдол бүрт
3. Шатлал хооронд эх шилжүүлэхэд хүндэрсэн
4. Эхийн болон бусад тусламжтай холбоотой гомдол гарсан тохиолдол бүрт
5. Анхан шатны бүртгэл маягтуудад яаралтай дуудлагын цаг минут, үзүүлсэн тусламжийн байдлыг үнэн зөв бүртгэж тэмдэглээгүй
6. Яаралтай тусламж үйлчилгээнд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материалын хангалт 80 хувиас доош хангасан тохиолдолд
7. Эмнэлэгт эмчлэгдэж буй өвчтөний биеийн байдлыг дутуу үнэлснээс өвчтөний биеийн байдал хүндрэх, амь нас эрсдэх
8. Өвчтөний биеийн байдлыг хэт хүндрүүлэн дараагийн шатны эмнэлэгт тээвэрлэсэн

Нэгдсэн эмнэлэгт хамааралтай заалт

1. Эргэн мэдээлэл хийгээгүй (эх нярайг төрөхөөс гарахад мэдээлэх төрөлтийн тухай картанд тэмдэглэл хийх, ЭХЭМД-т тэмдэглэл хийх ..)
2. Сумаас ирсэн эхчүүдийг ЭМС-ын 39 тоот тушаалын дагуу нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээ хийж зөвлөлгөө өгөөгүй тохиолдол
3. Перинаталь эндэгдлийн 3 тохиолдол тутамд
4. Хоног болоогүй нас баралт хагас бүтэн жилээр өмнөх оны түвшнээс 50 хувиас доош буураагүй бол
5. Хүүхдийн эндэгдлийн 3 тохиолдол тутамд (перинаталь эндэгдлийг тусгай тооцно)

СДЭ.СӨЭМТөвтэй хамааралтай заалт

1. Жирэмсний хожуу хүндрэлийн хүнд хэлбэрийн тохиолдолд
2. Товлолын дагуу өртөмтгий бүлэг тодорхойлох, үзлэг шинжилгээнд хамруулаагүй
3. Эмзэг бүлгийн эхчүүдийг жирэмслүүлсэн тохиолдол бүрт
4. Жирэмсэн эх хүндэрч СЭМТ-д болон гэрт хагалгаа хийгдэх (хагалгааны дараа хүндрэлгүй бол)
5. Хүүхэд, нярайн эндэгдлийн тохиолдол бүрт (хоног болоогүй нас баралтыг улаан картаар тооцно.
6. Сэхээн амьдруулах эрчимт эмчилгээний өрөөг тохижуулаагүй, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг байрлуулаагүй
7. Тусламж авч чадалгүй гэрээр гэнэт нас барсан тохиолдол тутамд
8. Аймгийн нэгдсэн эмнэлэгт хүндэрч ирсэн тусламж үйлчилгээний хожимдол бүрт (эх , нярай, хүүхэд ,гэмтэл, мэс засал, бусад
9. ХӨЦМ-ийн хэрэгжилт хангалтгүй (тандалтаар)

Улаан карт олгох заалт:

Эрүүл мэндийн бүх шатлалын байгууллагат хамааралтай заалт:

1. Эхийн эндэгдэл гаргасан тохиолдол
2. Жирэмсний хяналтын явцад болон төрөх тасагт эмчлэгдэж байгаад ураг амьгүй болох
3. Төрлөг удирдах явцад ураг амьгүй болох
4. Төрөлт удирдах явцад умай урагдах
5. Ноцтой хүндрэлийн тохиолдол бүрт
6. Шар картыг 3-аас дээш удаа авсан тохиолдолд
7. Яаралтай тусламжийн дуудлага саатсанаас болон гүйцэтгээгүйгээс хүний амь эрсдсэн , ноцтой хүндрэл гарсан

Нэгдсэн эмнэлэгт хамааралтай заалт

1. Релапротомия
2. Төрөх тасагт эмчлэгдэж байгаад эх манас таталтанд орсон
3. Хоног болоогүй нас баралтын 3 тохиолдол тутамд (өмнөх тооцсон тохиолдлоо оруулахгүй)

СДЭ.СӨЭМТөвтэй хамааралтай заалт

1. Жирэмсний хяналтгүйгээр эх хүндэрсэн
2. Эх манас таталтанд орсон
3. Хоног болоогүй нас баралт тутамд
4. Хүүхдийн нас баралт гэрт гарсан тохиолдол бүрт

Карт олгох,эргэн мэдээлэл хийх:

1. Жилдээ 2 удаа хагас бүтэн жилээр дүгнэн чанарын картыг олгоно .
2. Картаар үнэлэхэд Эрүүл мэндийн байгууллагуудын хагас бүтэн жилийн чанарын , статистик үзүүлэлтүүд болон явцын хяналтын үнэлгээ дүнг харгалзана.
3. Явцын хяналтаар холбогдох бичиг баримт үзлэгийн журнал карт, тэмдэглэлүүдийг үзэн баримтжуулна

4. Аймгийн нэгдсэн эмнэлэгт хөдөөнөөс ирж тусламж үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчдийн хүндрэл хожимдлын шалтгаанд хийсэн судалгаа, дүгнэлтийг НЭ-ийн чанарын алба, удирдлага болон ерөнхий мэргэжилтнүүдээс авч тооцно.
5. Улирлаар (сараар) тусламж үйлчилгээний үзүүлэлтэд хийсэн үнэлгээ, хүндрэл хожимдлын тохиолдлуудын эргэн мэдээллийг сумдад хүргүүлнэ
6. Байгууллагууд эх хүүхдийн чиглэлээр зохион байгуулсан ажлуудаа баримтжуулан тайлан бичсэн байна(өдөрлөг, нээлттэй хаалганы өдөр гэх мэт)
7. Үнэлгээний баг: ЭМГ-ын орлогч, эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
ЭМГ-ын эхийн тусламж хариуцсан мэргэжилтэн
ЭМГ-ын суурь тусламж, яаралтай тусламж хариуцсан
мэргэжилтэн
ЭМГ-ын Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн
Бусад шаардлагатай мэргэжилтнүүдийн татан оролцуулна
8. Үнэлгээний баг үнэлгээг хийж Чанарын карт олгох санал үндэслэлийг ЭМГ-ын даргат танилцуулан баталгаажуулж албан бичгээр тухайн эрүүл мэндийн байгууллагат болон засаг даргын тамгын газарт хүргүүлнэ.
9. Улаан картыг олгох заалтын дагуу анхны удаа олгохдоо цалингийн 10 хувиар давтан буюу улаан картын шалгуур үзүүлэлтээс давхцах тохиолдлуудад 1 удаагийн картаар 20-30 хувь хүртэл цалин бууруулах
10. Анхааруулгын шар картыг олгохдоо мөн үндэслэлийг дурдан анхааруулж зөвлөмж хүргүүлнэ. 3 ба түүнээс дээш удаа шар карт авсан тохиолдолд хариуцлагын улаан карт олгоно. Шар картын шалгуур үзүүлэлтүүд давхцах тохиолдлуудад үзүүлэлт бүрээр картыг тооцон улаан карт авах тоонд хүрсэн тохиолдолд (3 шалгуур үзүүлэлт зэрэг) шууд улаан карт олгоно.
11. Ногоон картыг шалгуур үзүүлэлтийн дагуу үндэслэлийг гарган цалингийн 10-30 хүртэл хувиар нэмэхээр санал хүргүүлнэ. Заалтуудаас бүгд зөрчилгүй байж ногоон картны болзол хангагдана
12. Ижил төстэй заалтууд давхцсан тохиолдолд тухайн үедээ хянан үзэж нэг заалтаар авч болно



ЭМГ-ын даргын 2014 оны 2 сарын 19 өдрийн 39 тоот тушаалын лхавсралт




УРАМШУУЛЛЫН КАРТ №

..... тусламж
..... танаа

..... тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад идэвхи санаачлага гаргаж тусламж үйлчилгээний удирдамж, стандарт, холбогдох эрх зүйн орчныг ханган ажиллаж бодит үр дүн гаргасан явдалд талархан урамшууллын картыг цалингийн хувиар сар урамшуулах эрхтэйгээр шагнаж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

201... оны ... сарын ... өдөр



ЭМГ-ын даргын 2014 оны 2 сарын 25 өдрийн 39 тоот тушаалын дахавсралт



АНХААРУУЛГЫН КАРТ

..... ОВОГТОЙ ТАНАА

..... тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад идэвхи санаачлагагүй, холбогдох удирдамж, стандарт, эрх зүйн орчныг ханган ажиллахад бодит үр дүн гарахгүй байгааг сануулж анхааруулгын картыг олгож байна

ЗРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

ЭМГ-ын даргын 2014 оны 2 сарын
25 өдрийн 39 тоот тушаалын захиасралт



ХАРИУЦЛАГЫН КАРТ

.....ОВОГТОЙТанаа

..... тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад идэвхи санаачлагагүй, удаа дараа зөрчил дутагдал гарган тусламж үйлчилгээний удирдамж, стандарт, холбогдох эрх зүйн орчныг хангаж ажиллахгүй хариуцсан ажлын чиглэлээр бодит үр дүн гарахгүй байгааг тэмдэглэн хариуцлагын картыг цалингийн хувиар ... сараар суутгах арга хэмжээг тооцож байна

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР



ЭМГ-ын даргын 2014 оны 2 сарын 25 өдрийн 39 тоот тушаалын 3-р хавсралт

ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ЧАНАРЫН КАРТ АШИГЛАСАН ТАЙЛАН

Эрүүл мэндийн байгууллагын нэр.....

Он сар өдөр

№	Картын төрөл		Карт авсан хүний тоо	Үүнээс			Урамшуулал , хариуцлагын мөнгөний хэмжээ
				Эмч	Сувилагч тусгай мэргэжилтэн	Бусад	
1	ЭМГ-аас	Ногоон					
2		Шар					
3		Улаан					
4	Үндсэн байгууллагаас	Ногоон					
5		Шар					
6		Улаан					
7	Бүгд дүн						

Жич : Чанарын карт авсан хүний тоо давхардаж тоологдож болно.

Тайлан гаргасан:

Албан тушаал
Овог нэр